



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/85/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхцэцэг**

Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК**

Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

УЛААНБАДРАХ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.НАМЖИЛСҮРЭН  
ТАНАА

2020.02.28 № 1-6/206  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Аудитын гол асуудал**


Бараа материалын зарлагыг анхан шатны баримтыг үндэслэн тухай бүр бүртгэлгүй, сарын эцэст бөөн дүнгээр бүртгэсэн, бараа материалын дэд данс хооронд ангилал буруу хийсэн, бэлтгэн нийлүүлэгчээс авсан бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг авлага, өглөгийн дансаар дамжуулалгүй орлогоор бүртгэсэн, жолоочийн орон тоо батлагдаагүй байхад хавсран ажилласны нэмэгдэл олгосон зэрэг 66,800.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Намжилсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020. оны 1 дүгээр сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн .... дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Эх хэлээрээ цэгцтэй ярьж, алдаагүй цэвэр бичдэг, зөв дадал, хандлагатай иргэнийг төлөвшүүлэх, ёс зүйн дүрмийг сахисан Чадварлаг багийг бүрдүүлэхэд оршино.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ээлжит хичээлийн бэлтгэл, үр дүнг сайжруулах.
- Сурлагын чанарт ахиц гаргах.
- Албан хаагч бүр өдөр тутмын хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэх. Суралцагчийг номоор дамжуулан төлөвшүүлж, хөгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХАОАТ-ын тухай хууль
- Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05, 06, 07 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 24, 25 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.04.03-ны өдрийн 126 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.10.30-ны 395 дугаар тогтоол

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ACOLOUR программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 509,200.1 мянган төгрөгөөс тооцон 5,092.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,092.0 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үеэс өөрчлөгдөөгүй байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 346,735.1 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	65,865.8	76,933.5	11,057.7
Үндсэн хөрөнгө	1,177,951.0	1,350,941.9	172,990.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,081,140.3</b>	<b>1,427,875.4</b>	<b>346,735.1</b>
Өр төлбөр	562.3	-	(562.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,081,090.6	1,427,875.4	347,297.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,081,140.3</b>	<b>1,427,875.4</b>	<b>346,735.1</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь дээд шатны байгууллагаас орж ирсэн 1,690.7 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг болон нийт 68,060.7 мянган төгрөгөөр материал нэмэгдэж, 53,103.2 мянган төгрөгийн зарлага гаргаснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэл нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан байна. Бараа материалын дансны ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь дээд шатны төсвийн захирагчийн хөрөнгө оруулалтаар 197,862.3 мянган төгрөгийн сургуулийн барилгын их засвар, тус суманд үйл ажиллагаа эрхэлдэг Бадрах Энержи ХХК компанийн хөрөнгө оруулалтаар 180,900.0 мянган төгрөгийн дотуур байрны их засвар, бусад байгууллага хувь хүнээс орж ирсэн хөрөнгө оруулалтаар 4,685.9 мянган төгрөгийн ном, Аймгийн засаг дарга шийдэж, төсөвт нэмж оруулсан 10,000.0 мянган төгрөг болон өөрийн нэмэлт орлого 1,092.0 мянган төгрөг, нийт 11,092.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдаж авснаар нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 13,838.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр данс оны эцэст үлдэгдэлгүй байна. Оны эхний 562.3 мянган төгрөгийн үлдэгдэл бүрэн барагдсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,427,875.4 мянган төгрөг болж, 347,297.9 мянган төгрөгөөр өссөн нь Тайлант үеийн үр дүн 347,297.9 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд 468,540.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 468,540.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 468,540.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 468,540.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 413,090.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 55,450.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 423,789.6 мянган төгрөг буюу 90.45 хувьтай байна. Батлагдсан төсөв 44,750.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд: Байр ашиглалттай холбоотой зардал 23,782.5 мянга, цалин 16,153.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлон нөлөөлжээ. Энэ нь 2019 онд төвлөрсөн халаалттай болно гэж тооцоолоод халаалтын төсвийг нэмсэн боловч хэрэгжээгүйгээс 23,782.5 мянган төгрөг, цалингийн зардал төсөвлөсөн урамшууллыг олгоогүйгээс тус тус шалтгаалжээ.

Хэмнэгдсэн 44,750.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

**Нэмэлт төсөв:** Заалны болог түрээсийн орлогоор нийт 2245.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс Сургууль болон дотуур байранд хаяг, гадна гэрэлтүүлгэнд 1,765.0 мянга, сурагчдын бүжгийн гутал хийлгэхэд 480.2 мянга, нийт 2,245.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 500 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж, нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 66,816.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс залруулга хийгдээгүй. Аудитаар илэрсэн 66,816.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвөөс 44,751.2 мянган төгрөг хэмнэгдэж, төвлөрүүлсэн байна. Энэ нь 2019 онд төвлөрсөн халаалттай болно гэж тооцоолоод халаалтын төсвийг нэмсэн боловч хэрэгжээгүйгээс 23,782.5 мянган төгрөг, цалингийн зардалд төсөвлөсөн урамшууллыг олгоогүйгээс тус тус шалтгаалжээ.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100.0 хувьтай байна. Үүнд:

Албан шаардлага:

Түлш нүүрс, хоол хүнс, эд хогшил, урсгал засварын зардалд нийт 42,908,2 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчсөн.

Хэрэгжилт: 2019 оны санхүүгийн жилд худалдан авах ажиллагааны тухай хуулийг мөрдөж ажилласан.

Зөвлөмж:

1.Төсвийн зарцуулалтыг шилжүүлэхдээ зарим ажил гүйлгээнд Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8-д заасан нотлох баримтыг бүрдүүлээгүй.

Хэрэгжилт: Төсвийн хөрөнгийг зарцуулахдаа анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллажээ.

2.Төсвийн тухай хуулийн 22.6.7-д “Төсвийн шууд захирагч нь төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах”, НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийгээгүй”.

Хэрэгжилт: 2019 оны хагас жилээр болон 11 дүгээр сард Байгууллагын өмч хамгаалах зөвлөл, жилийн эцсээр сумын төрийн сангийн хэлтсээс комисс байгуулж тооллого хийсэн.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 66,816.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 5,092.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг цаг тухай бүрт бүртгээгүй сарын эцэст орлого, зарлага гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Үнэлгээ ба хувиарлалт, Тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Бүртгэлээр тавих хяналт сулрах, алдагдах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын явцад залруулж амжаагүй.

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн. Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Авлага, өглөгийн тодруулга буруу илэрхийлэгдэнэ.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын явцад залруулж амжаагүй.

## **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

### 3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалыг орлогод бүртгэхдээ буруу ангилан бүртгэсэн. Энэ нь Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.13, 5.1.4, 20.2.3 заалтуудыг зөрчсөн байна.

### 3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн байдлын тайлан, бараа материалын тодруулга буруу илэрхийлэгдэнэ.

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын явцад залруулж амжаагүй.

## **3.4 Зардлын данстай холбоотой асуудал**

### 3.4.1 Илрүүлэлт:

Батлагдсан орон тоогүй атлаа хавсран ажилласан нэмэгдэл цалин олгосон. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5.1.3, 16.5.2, 16.5.3 заалтуудыг зөрчсөн байна.

### 3.4.2 Эрсдэл:

Цалингийн зардал өсөж, үр дүн буурна.

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тайлбар хийгээгүй.

## **3.5 Балансын данстай холбоотой асуудал**

### 3.5.1 Илрүүлэлт:

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг бусад орлогоор бүртгэсэн. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалыг зөрчсөн байна.

### 3.5.2 Эрсдэл:

Авлага, өглөгийн тодруулга буруу илэрхийлэгдэнэ.

### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын явцад залруулж амжаагүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,817,001.27	79,400,687.27
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,865,751.35	76,933,498.08
35	БАРАА МАТЕРИАЛ	65,865,751.35	76,933,498.08
351	Түүхий эд материал	9,244,606.66	14,849,810.66
35110	Тусгай зориулалттай материал	9,047,766.66	14,496,620.66
35130	Эм боох материал	196,840.00	353,190.00
354	Хангамжийн материал	56,621,144.69	62,083,687.42
35410	Бичиг хэргийн материал	1,490,974.00	1,560,717.00
35420	Аж ахуйн материал	7,805,417.50	7,132,927.50
35440	Түлш, шатах тослох материал	742,340.00	5,986,750.03
35460	Хүнсний материал	3,367,254.50	5,682,688.40
35470	Бусад хангамжийн материал	43,215,158.69	41,720,604.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,015,274,515.23	1,350,941,950.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,015,274,515.23	1,350,941,950.58
392	Биет хөрөнгө	1,014,362,515.23	1,350,029,950.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	900,359,920.00	1,279,122,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,000.00	-26,129,898.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,006,944.37	-21,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,249,889.67	129,174,275.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,039,219.73	-83,927,921.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,325,642.54	92,630,690.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,927,411.56	-66,138,752.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,573,512.00	23,573,512.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,657,929.32	-10,013,572.16
39217	Ном	7,030,056.00	11,739,315.11
393	Биет бус хөрөнгө	912,000.00	912,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	912,000.00	912,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,081,140,266.58	1,427,875,448.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	562,731.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	562,731.00	00.00
413	Өглөг	562,731.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	314,516.00	00.00
4136	Бусад өглөг	248,215.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	248,215.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,080,577,535.58	1,427,875,448.66
51	Засгийн газрын хувь оролцоо	1,080,577,535.58	1,427,875,448.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	926,586,877.86	926,586,877.86
51101	Өмч: - төрийн	926,586,877.86	926,586,877.86
512	Хуримтлагдсан үр дүн	-419,583,733.15	-71,772,701.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-419,583,733.15	-419,070,614.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	347,297,913.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	573,574,390.87	573,061,271.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,081,140,266.58	1,427,875,448.66

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	637,394,700.00	608,768,900.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	374,807,700.00	856,498,046.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,362,800.00	387,957,746.11
120	Нийтлэг татварын бус орлого	8,362,800.00	387,957,746.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,362,800.00	387,957,746.11
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,647,500.00	2,819,950.00
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,715,300.00	385,137,796.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	987,200.00	55,450,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,457,700.00	413,090,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	987,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	987,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	55,450,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	55,450,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	303,437,376.91	508,367,939.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,437,376.91	508,367,939.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,511,376.91	452,113,912.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,643,510.70	296,888,508.00
210101	Үндсэн цалин	124,506,826.20	290,504,418.00
210102	Нэмэгдэл	18,201,341.00	6,384,090.00
210104	Урамшуулал	6,238,487.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,696,856.50	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,113,618.00	37,300,435.00
210201	Тэтгэврийн даатгал	12,185,091.00	26,957,701.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,503,005.00	1,742,323.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,202,404.00	2,086,472.00
210204	Ажилгүйдлийн даатгал	259,376.00	853,993.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,963,742.00	5,659,946.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,059,520.00	25,961,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,911,520.00	5,226,650.00
210302	Түлш, халаалт	7,368,000.00	19,879,050.00
210303	Цэвэр, бохир ус	780,000.00	856,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,275,734.37	13,504,213.17
210401	Бичиг хэрэг	911,260.00	1,872,854.00
210402	Тээвэр, шатахуун	1,257,480.00	423,439.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	345,912.00	181,400.00
210404	Ном, хэвлэл	98,450.00	598,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000.00	483,050.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,175,940.00	4,282,990.00
210408	Бараа материал акталсны зардал	251,692.37	5,662,079.20
2105	Нормативт зардал	15,822,167.30	17,352,568.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	219,990.00	117,250.00
210502	Хоол, хүнс	14,938,227.30	17,235,318.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	663,950.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,164,780.00	00.00
210604	Урсгал засвар	2,164,780.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	729,600.00	1,737,600.00
210702	Дотоод албан томилолт	729,600.00	1,737,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	526,710.00	760,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	526,710.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,175,736.54	58,608,888.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,397,911.29	296,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,481,125.00	376,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,296,700.25	57,936,888.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,926,000.00	56,254,027.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,926,000.00	11,502,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,926,000.00	10,942,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	560,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	20,968,677.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	20,968,677.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	23,782,550.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	23,782,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	71,370,323.09	348,130,106.21
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	19,953,311.29	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	19,953,311.29	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	832,193.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	832,193.13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	19,953,311.29	-832,193.13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	91,323,634.38	347,297,913.08

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	544,955,800.00	605,163,500.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	201,307,900.00	471,360,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,647,500.00	2,819,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,647,500.00	2,819,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,647,500.00	2,819,950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,647,500.00	2,819,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	199,660,400.00	468,540,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	198,673,200.00	413,090,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	987,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	987,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	55,450,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	55,450,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	184,278,437.00	460,268,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,278,437.00	460,268,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,918,637.00	403,775,223.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,388,592.00	297,203,023.00
210101	Үндсэн цалин	108,346,991.00	212,528,931.00
210102	Нэмэгдэл	14,232,033.00	58,185,559.00
210104	Урамшуулал	6,018,271.00	26,488,533.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,791,297.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,958,226.00	37,012,436.00
210201	Тэтгэврийн даатгал	8,723,871.00	25,117,991.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,080,485.00	2,505,445.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,120,098.00	2,934,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,797.00	586,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,757,975.00	5,868,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,056,112.00	29,667,650.00
210301	Гэрэл, цахилгаан	3,399,112.00	5,226,650.00
210302	Түлш, халаалт	4,147,000.00	23,585,000.00
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	856,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,892,052.00	5,547,150.00
210401	Бичиг хэрэг	110,000.00	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	869,880.00	2,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	215,362.00	192,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	897,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	200,000.00	483,050.00

	мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496,810.00	1,475,000.00
2105	Нормативт зардал	8,736,145.00	21,320,367.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	280,800.00
210502	Хоол, хүнс	8,736,145.00	19,792,367.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,247,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	3,037,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,037,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	230,000.00	1,737,600.00
210702	Дотоод албан томилолт	230,000.00	1,737,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,510.00	760,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,510.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	443,000.00	7,489,997.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	285,000.00	195,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	158,000.00	7,294,997.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,359,800.00	56,493,027.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,359,800.00	11,741,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,359,800.00	10,942,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	799,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	20,968,677.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	20,968,677.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	23,782,550.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	23,782,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,029,463.00	11,092,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	11,092,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	11,092,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	11,092,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,092,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-11,092,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,029,463.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,029,463.00	00.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	573,574,390.87	-419,583,733.15	1,080,577,535.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	513,118.94	513,118.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	926,586,877.86	573,574,390.87	-419,070,614.22	1,081,090,654.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-513,118.94	00.00	-513,118.93
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	347,297,913.08	347,297,913.08
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	573,061,271.94	-71,772,701.14	1,427,875,448.66

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	468,540,300.00	423,789,623.00	44,750,677.00	90.4
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	468,540,300.00	423,789,623.00	44,750,677.00	90.4
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	454,573,300.00	412,047,823.00	42,525,477.00	90.6
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	313,356,000.00	297,203,023.00	16,152,977.00	94.8
Үндсэн цалин	221,244,000.00	212,528,931.00	8,715,069.00	96.0
Нэмэгдэл	63,007,000.00	58,185,559.00	4,821,441.00	92.3
Урамшуулал	29,105,000.00	26,488,533.00	2,616,467.00	91.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,044,400.00	37,012,436.00	1,031,964.00	97.2
Тэтгэврийн даатгал	26,308,200.00	25,117,991.00	1,190,209.00	95.4
Тэтгэмжийн даатгал	2,347,200.00	2,505,445.00	(158,245.00)	106.4
ҮОМШӨ-ний даатгал	2,934,100.00	2,934,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	586,900.00	586,900.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	5,868,000.00	5,868,000.00	-	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,450,200.00	29,667,650.00	23,782,550.00	55.5
Гэрэл, цахилгаан	6,834,600.00	5,226,650.00	1,607,950.00	76.4
Түлш, халаалт	45,348,000.00	23,585,000.00	21,763,000.00	52.0
Цэвэр, бохир ус	1,267,600.00	856,000.00	411,600.00	67.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,978,000.00	3,831,950.00	146,050.00	96.3
Бичиг хэрэг	300,000.00	300,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	570,000.00	192,000.00	378,000.00	33.6
Ном, хэвлэл	348,000.00	346,900.00	1,100.00	99.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	483,050.00	(233,050.00)	193.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	310,000.00	310,000.00	-	100.0
<b>Нормативд зардал</b>	22,230,700.00	20,840,167.00	1,390,533.00	93.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,800.00	280,800.00	-	100.0

Хоол, хүнс	21,179,900.00	19,792,367.00	1,387,533.00	93.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,000.00	767,000.00	3,000.00	99.6
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,540,000.00	13,540,000.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	6,655,000.00	6,655,000.00	-	100.0
Тавилга	4,885,000.00	4,885,000.00	-	100.0
Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	1,750,000.00	1,737,600.00	12,400.00	99.2
Дотоод албан томилолт	1,750,000.00	1,737,600.00	12,400.00	99.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	760,000.00	760,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,000.00	760,000.00	-	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7464000.00	7454997.00	9,003.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	204,000.00	195,000.00	9,000.00	95.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,260,000.00	7,259,997.00	3.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13967000.00	11741800.00	2,225,200.00	84.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,967,000.00	11,741,800.00	2,225,200.00	84.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,167,000.00	10,942,800.00	2,224,200.00	83.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	799,000.00	1,000.00	99.8
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	468,540,300.00	423,789,623.00	44,750,677.00	90.4
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	413,090,100.00	392,121,423.00	20,968,677.00	94.9
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	413,090,100.00	392,121,423.00	20,968,677.00	94.9
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	55,450,200.00	31,667,650.00	23,782,550.00	57.1
Орон нутгийн төсвөөс	55,450,200.00	31,667,650.00	23,782,550.00	57.1

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		2,819,400.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		2,819,400.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		2,819,400.00
Хангамж, бараа материалын зардал		1,739,200.00
Ном, хэвлэл		574,200.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,165,000.00
Нормативт зардал		480,200.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		480,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал		600,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		600,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		2,819,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		2,819,400.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,819,400.00

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2019.12.31	Аудитын нэр: <b>Улаанбадрах сумын ЕБС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: ДГА-2020/85/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бичсэн.	4,100.0	Зөвлөмж өгөв	Захирал, нябо	Н.Намжилсүрэн, Б.Уранбилэг
2	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон жирэмсэн эхийн тэтгэмжийн мөнгийг нийгмийн даатгалын газраас авахаар тооцсон үед орлого, мөнгөн хөрөнгө дансыг харьцуулж, дансны бичилт буруу хийж байна.	143.6	Зөвлөмж өгөв	Захирал, нябо	Н.Намжилсүрэн, Б.Уранбилэг
3	Хүнс, шатахуун, түлээ, нүүрс, бичиг хэргийн болон аж ахуйн материал, эмийн зарлагыг сарын эцэст бөөн дүнгээр бүртгэж байна.	58,683.1	Зөвлөмж өгөв	Захирал, нябо	Н.Намжилсүрэн, Б.Уранбилэг
4	Тусгай зориулалтын материалд ном бүртгэсэн.	1,989.9	Зөвлөмж өгөв	Захирал, нябо	Н.Намжилсүрэн, Б.Уранбилэг
5	Жолоочийн орон тоо батлагдаагүй байхад галчид жолооч давхар хийдэг гэж 5хавсарсны нэмэгдэл олгосон.	1,870.0	Зөвлөмж өгөв	Захирал, нябо	Н.Намжилсүрэн, Б.Уранбилэг